МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 18 өдөр　　Дугаар А/317　　Улаанбаатар хот

Коронавируст халдварын үед эмнэлзүйн
зөвлөх баг ажиллуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 заалт, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх “Эмнэлзүйн зөвлөх багийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, “Эмнэлзүйн чиглэлээр мэргэжил арга зүйгээр хангаж, зөвлөн туслах үйл ажиллагааны журам”-ыг хоёрдугаар, “Зөвлөх эмчийн хуваарь”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус батлагсугай.

2. Коронавируст халдварын дэгдэлтийн хугацаанд тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эмнэлзүйн зөвлөх багийн гишүүд, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, коронавируст халдварын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Зөвлөх багийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахыг Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Буянтогтох)-т, зөвлөгөө авах телемидициний техникийн болон программ хангамжийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Ц.Эрдэмбилэг)-д даалгасугай.

САЙД　　　　С.ЭНХБОЛД

141211452

Эрүүл мэндийн сайдын 2021 оны
05 сарын 18 өдрийн А/317 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

# ЭМНЭЛЗҮЙН ЗӨВЛӨХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Уушги судлалын тусламж, үйлчилгээний чиглэлээр:

Ц.Төмөр-Очир, Улсын гуравдугаар төв эмнэлгийн дарга, АУ-ны доктор, дэд профессор, Дотрын зөвлөх зэргийн эмч

Д.Ичинноров, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Уушги, харшил судлалын тэнхмийн профессор, АУ-ны доктор, дэд профессор

Б.Одончимэг, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Уушгины тасгийн эрхлэгч, АУ-ны доктор, тэргүүлэх зэргийн эмч

Эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээний чиглэлээр:

М.Наранпүрэв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн дэд захирал, тэргүүлэх зэргийн эмч

Б.Цолмон, Интермед эмнэлгийн Эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч, АУ-ны магистр, тэргүүлэх зэргийн эмч

Ц.Ганбат, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Эрчимт эмчилгээний зөвлөх

Ц.Чинбаяр, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дэд захирал, АУ-ын магистр, клиникийн профессор, тэргүүлэх зэрэгтэй,

Х.Чулуунчимэг, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн эрчимт эмчилгээний эмч, тэргүүлэх зэргийн эмч

Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:

С.Хишгээ, Эх, хүүхдийн эрүүл мэндийн төвийн Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн ерөнхий зөвлөх эмч, клиникийн профессор эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх зэргийн эмч,

Д.Мөнхцэцэг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эх барих эмэгтэйчүүд судлалын тэнхимийн эрхлэгч, АУ-ны доктор

Хүүхэд, эх барих, эмэгтэйчүүдийн эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээний чиглэлээр:

Ш.Энхтөр, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал, АУ-ны доктор, клиникийн профессор, зөвлөх зэргийн эмч

Ц.Эрдэнэбаяр, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эх барихын эрчимт эмчилгээний эмч, клиникийн профессор, зөвлөх зэргийн эмч

Эрүүл мэндийн сайдын 2021 оны
05.... сарын 11 өдрийн А/317 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

# ЭМНЭЛЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАЖ, ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

## НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Коронавируст халдварын тархалтын нөхцөл байдалд үндэслэн цар тахлыг хохирол багатай даван туулах зорилгоор эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, оношилгоо, эмчилгээнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн яамны дэргэд үндэсний хэмжээнд коронавируст халдварын эмнэлгийн тусламж, үйлчилгээний уушги судлал, эх барих, эмэгтэйчүүд, эрчимт эмчилгээний төрөлжсөн мэргэшлээр зөвлөх үүрэг бүхий эмнэлзүйн зөвлөх баг байгуулна.

1.3. КОВИД-19 халдварын эмнэлзүйн зөвлөх багийн гишүүд нь зөвхөн эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ, оношилгоонд зөвлөн туслах чиг үүрэгтэй бөгөөд хуулийн байгууллагад эмнэлзүйн зөвлөлийн гишүүний нэрийн өмнөөс шинжээч эмчээр ажиллаж, дүгнэлт гаргах үүрэг хүлээхгүй, ашгийн төлөө ямар нэг үйл ажиллагаанд оролцохгүй болно.

1.4. Зөвлөгөө авах эрүүл мэндийн байгууллага болон мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зөвлөх багийн гишүүд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн үндсэн тулгуур зарчмыг баримтлан, харилцан хүндэтгэлтэй хандаж, хамтран ажиллана.

1.5. Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газарт зөвлөх багийн үйл ажиллагааг зохион байгуулалтаар хангах багийг байгуулна.

1.6. Энэ журмын 1.5 дахь хэсэгт дурдсан баг нь зөвлөх багийн үйл ажиллагаа болон санал, зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн арга хэмжээг яамны холбогдох газар болон байгуулллагатай хамтран зохион байгуулна.

## ХОЁР. Зөвлөх багийн гишүүдийн үүрэг

2.1. Эмнэлзүйн зөвлөх нь хуваарьт аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын коронавируст халдварын тусламж, үйлчилгээнд өөрийн төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллгааг утсаар шуурхай зохион байгуулна.

2.2. Мэргэжил арга зүйгээр хангах үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллагын эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгч бүрийн биеийн байдал, оношилгоо, эмчилгээний талаарх мэдээлэлтэй танилцаж, зөвлөгөө, чиглэл өгнө.

2.3. Ковид-19 халдварын шалтгаант нас баралтын шалтгаан хамаарал, нөлөөлөх хүчин зүйлд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулна.

2.4. Хуваарьт эрүүл мэндийн байгууллагын коронавируст халдварын оношилгоо, эмчилгээний эргэлзээ, яаралтай шийдвэр гаргах, эмнэлэг хооронд шилжүүлэх үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө өгч дэмжин ажиллах

2.5. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон олон улсын коронавируст халдварын хариу арга хэмжээ, оношилгоо, эмчилгээний судалгаа, нотолгоонд үндэслэн эмнэлзүйн заавар, удирдамж, зөвлөмж, гарын авлагыг боловсруулах үйл ажиллагаанд оролцоно.

2.6. Зөвлөн туслах аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад газар дээр нь очиж тасаг нэгжийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, үйл ажиллагаатай танилцаж, дүгнэлт хийх, зөвлөмж, чиглэл өгч мэргэжил арга зүйгээр хангаж болно.

2.7. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах санал, санаачилга, сургалтыг зохион байгуулж, ур чадварыг дээшлүүлэхэд мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангах үйл ажиллагааг эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

2.8. Хариуцсан аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын КОВИД-19 халдварын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн саналыг Эрүүл мэндийн яаманд болон тухайн эрүүл мэндийн байгууллагад гаргана.

2.9. Зөвлөх багийн гишүүд зөвлөн туслах үйлчилгээ болон мэргэжил арга зүйгээр хангахад чиглэсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг 7 хоног бүрийн Пүрэв гарагт Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын холбогдох мэргэжилтэнд мэдээлэл ирүүлнэ.

## ГУРАВ. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар, коронавируст халдварын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын үүрэг

3.1. Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан коронавируст халдвар (КОВИД-19)-тай иргэнийг хэвтүүлэн эмчлэх үндсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлийн хуваарилалтад орсон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд тухайн дүүрэгт КОВИД-19 халдвар батлагдсан тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагыг (цаашид эмнэлэг гэх) эмнэлзүйн чиглэлээр мэргэжил арга зүйгээр

дэмжих багийг байгуулж, зөвлөгөө мэдээлэл авах зохион байгуулалтыг тодорхой болгоно.

3.2. Эмнэлэг нь 3.1-т заасан төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн мэргэжил арга зүйгээр дэмжих багт хандах бөгөөд өөрийн эмнэлэг байрших аймаг, дүүргээр энэхүү тушаалын гуравдугаар хавсралтад заасан зөвлөх багт телемидицин болон утсаар хандана.

3.3. Эмнэлэг нь өдөр бүр эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгч бүрийн биеийн байдал, оношилгоо, эмчилгээний талаарх мэдээллийг эрчимт эмчилгээний зөвлөх эмчид танилцуулж, зөвлөгөө, чиглэлийг нь өвчний түүхэнд тэмдэглэн баримтжуулж, хэрэгжүүлнэ.

3.4. Эмнэлгийн мэргэжилтний оношилгоо, эмчилгээний ур чадварыг сайжруулах тасралтгүй сурах, эмнэлзүйн чиглэлээр зөвлөгөө, дэмжлэг авах, цагийн төлөвлөлтийг зөвлөх эмчтэй хамтран гаргаж мөрдөнө.

**ДӨРӨВ. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үүрэг**

4.1. Коронавируст халдварын үед эмнэлзүйн зөвлөх баг, эрүүл мэндийн байгууллага цахимаар зөвлөгөө авах (телемидицин) техникийн болон программ хангамжийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах

4.2. Эрүүл мэндийн байгууллага болон зөвлөх багт телемидициний үйл ажиллагааны мэдээлэл сургалт, гарын авлагыг боловсруулж, түгээх

4.3. Цахимаар зөвлөгөө авсан тохиолдлын бичлэгийн архив үүсэх,

4.4. Зөвлөх багийн гишүүдийн цахимаар зөвлөгөө өгсөн үйл ажиллагааны тайланг 1 сар бүр Эрүүл мэндийн яаманд ирүүлнэ.

4.5. Телемидициний үйл ажиллагааг зохион байгуулахдаа Эрүүл мэндийн сайдын 2013 оны 330 дугаар тушаалын хэрэгжилтийг хангана.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны
05 сарын 18 өдрийн А/342 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД ЭМНЭЛЗҮЙН ЗӨВЛӨХ ЭМЧИЙН МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ХУВААРЬ, ХОЛБОО БАРИХ УТАСНЫ ДУГААР

| № | Аймаг | Зөвлөх багийн гишүүн | Мэргэжлийн чиглэл | Холбоо барих утасны дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | Архангай аймаг | Ц.Төмөр-Очир | Уушги судлал | 99037227 |
| | | М.Наранпүрэв | Эрчимт эмчилгээ | 99145624 |
| | | С.Хишгээ | Эх барих, эмэгтэйчүүд | 88119180 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 2 | Баянхонгор аймаг | Б.Одончимэг | Уушги судлал | 99197077 |
| | | Ц.Ганбат | Эрчимт эмчилгээ | 88084542 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 3 | Баян-Өлгий аймаг | Д.Ичинноров | Уушги судлал | 99971561 |
| | | Б.Цолмон | Эрчимт эмчилгээ | 88091982 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| | | С.Хишгээ | Эх барих, эмэгтэйчүүд | 88119180 |
| 4 | Булган аймаг | Ц.Төмөр-Очир | Уушги судлал | 99037227 |
| | | Ц.Чинбаяр | Эрчимт эмчилгээ | 88045030 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 5 | Говь-Алтай аймаг | Б.Одончимэг | Уушги судлал | 99197077 |
| | | Х.Чулуунчимэг | Эрчимт эмчилгээ | 99005862 |
| | | С.Хишгээ | Эх барих, эмэгтэйчүүд | 88119180 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 6 | Говьсүмбэр аймаг | Д.Ичинноров | Уушги судлал | 99971561 |
| | | М.Наранпүрэв | Эрчимт эмчилгээ | 99145624 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 7 | Дархан-Уул аймаг | Ц.Төмөр-Очир | Уушги судлал | 99037227 |
| | | Ц.Ганбат | Эрчимт эмчилгээ | 88084542 |
| | | С.Хишгээ | Эх барих, эмэгтэйчүүд | 88119180 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 8 | Дорноговь аймаг | Б.Одончимэг | Уушги судлал | 99197077 |
| | | Б.Цолмон | Эрчимт эмчилгээ | 88091982 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 9 | Дундговь аймаг | Д.Ичинноров | Уушги судлал | 99971561 |
| | | Ц.Чинбаяр | Эрчимт эмчилгээ | 88045030 |
| | | С.Хишгээ | Эх барих, эмэгтэйчүүд | 88119180 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 10 | Дорнод аймаг | Ц.Төмөр-Очир | Уушги судлал | 99037227 |
| | | Х.Чулуунчимэг | Эрчимт эмчилгээ | 99005862 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 11 | Орхон аймаг | Б.Одончимэг | Уушги судлал | 99197077 |
| | | М.Наранпүрэв | Эрчимт эмчилгээ | 99145624 |
| | | С.Хишгээ | Эх барих, эмэгтэйчүүд | 88119180 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 12 | Завхан аймаг | Д.Ичинноров | Уушги судлал | 99971561 |
| | | Ц.Ганбат | Эрчимт эмчилгээ | 88084542 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 13 | Өвөрхангай аймаг | Ц.Төмөр-Очир | Уушги судлал | 99037227 |
| | | Б.Цолмон | Эрчимт эмчилгээ | 88091982 |
| | | С.Хишгээ | Эх барих, эмэгтэйчүүд | 88119180 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 14 | Өмнөговь аймаг | Б.Одончимэг | Уушги судлал | 99197077 |
| | | Ц.Чинбаяр | Эрчимт эмчилгээ | 88045030 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 15 | Сүхбаатар аймаг | Д.Ичинноров | Уушги судлал | 99971561 |
| | | Х.Чулуунчимэг | Эрчимт эмчилгээ | 99005862 |
| | | С.Хишгээ | Эх барих, эмэгтэйчүүд | 88119180 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 16 | Сэлэнгэ аймаг | Ц.Төмөр-Очир | Уушги судлал | 99037227 |
| | | М.Наранпүрэв | Эрчимт эмчилгээ | 99145624 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 17 | Төв аймаг | Б.Одончимэг | Уушги судлал | 99197077 |
| | | Ц.Ганбат | Эрчимт эмчилгээ | 88084542 |
| | | С.Хишгээ | Эх барих, эмэгтэйчүүд | 88119180 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 18 | Увс аймаг | Д.Ичинноров | Уушги судлал | 99971561 |
| | | Б.Цолмон | Эрчимт эмчилгээ | 88091982 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 19 | Ховд аймаг | Ц.Төмөр-Очир | Уушги судлал | 99037227 |
| | | Ц.Чинбаяр | Эрчимт эмчилгээ | 88045030 |
| | | С.Хишгээ | Эх барих, эмэгтэйчүүд | 88119180 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 20 | Хөвсгөл аймаг | Б.Одончимэг | Уушги судлал | 99197077 |
| | | Х.Чулуунцэцэг | Эрчимт эмчилгээ | 99005862 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 21 | Хэнтий аймаг | Д.Ичинноров | Уушги судлал | 99971561 |
| | | М.Наранпүрэв | Эрчимт эмчилгээ | 99145624 |
| | | С.Хишгээ | Эх барих, эмэгтэйчүүд | 88119180 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 22 | Сонгинохайрхан дүүрэг | Ц.Төмөр-Очир | Уушги судлал | 99037227 |
| | | М.Наранпүрэв | Эрчимт эмчилгээ | 99145624 |
| | | С.Хишгээ | Эх барих, эмэгтэйчүүд | 88119180 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 23 | Баянзүрх дүүрэг | Д.Ичинноров | Уушги судлал | 99971561 |
| | | Ц.Чинбаяр | Эрчимт эмчилгээ | 88045030 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 24 | Хан-Уул дүүрэг | Д.Ичинноров | Уушги судлал | 99971561 |
| | | Б.Цолмон | Эрчимт эмчилгээ | 88091982 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 25 | Сүхбаатар дүүрэг | Б.Одончимэг | Уушги судлал | 99197077 |
| | | Ц.Ганбат | Эрчимт эмчилгээ | 88084542 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 26 | Чингэлтэй дүүрэг | Б.Одончимэг | Уушги судлал | 99197077 |
| | | Х.Чулуунчимэг | Эрчимт эмчилгээ | 99005862 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 27 | Баянгол дүүрэг | Ц.Төмөр-Очир | Уушги судлал | 99037227 |
| | | Х.Чулуунчимэг | Эрчимт эмчилгээ | 99005862 |
| | | С.Хишгээ | Эх барих, эмэгтэйчүүд | 88119180 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |
| 28 | Багануур, Налайх, Багахангай дүүрэг | Д.Ичинноров | Уушги судлал | 99971561 |
| | | Ц.Чинбаяр | Эрчимт эмчилгээ | 88045030 |
| | | Д.Мөнхцэцэг | Эх барих, эмэгтэйчүүд | 99056769 |
| | | Ш.Энхтөр | Хүүхдийн эрчимт эмчилгээ | 99059825 |
| | | Ц.Эрдэнэбаяр | Эх барихын эрчимт эмчилгээ | 99194964 |